

1997 ОНЫ МАЛ ТООЛЛОГО

ОРШИЛ

Хөдөө аж ахуйн салбарын нийт бүтээгдэхүүн 1997 онд өмнөх оныхоос 2.6 хувь өсөхөөр байгаа нь манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг хангахад чухал хүчин зүйл болов.

Манай орны эдийн засгийн үндсэн гол салбарын нэг болох хөдөө аж ахуйд нийт ажиллагсадын 40 гаруй хувь ажиллаж, дотоодын нийт бүтээгдэхүүний 30 орчим хувийг үйлдвэрлэж; экспортод хоёрдогч байр суурийг эзлэж байна.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн 80 гаруй хувийг эзэлдэг мал аж ахуйн салбарын хөгжил, түүний бүтээгдэхүүний өсөлтөөс улс орны эдийн засгийн бусад салбар ихээхэн шалтгаалдаг билээ. Нийт малын тоо 1997 оны эцэст 31.3 саяд хүрч, 1996 оныхоос 2 сая шахам толгойгоор өслөө.

1997 оны мал тооллого нь өмнөх жилүүдээс ялгагдах онцлогтой явагдав. Тооллоготой хамтруулан малчин өрхийн 11.2 хувийг түүвэрлэн авч малын тоогоор нь бүлэглэн, орлогыг нь тодорхойлож, тэдний соёл, ахуйн зарим үзүүлэлттэй холбон судлах зорилт тавьж хэрэгжүүлэв.

Мал тооллогын бэлтгэл зохион байгуулалтыг хангах, маягт, зааварчилгааг орон нутагт хүргүүлэх, тооллогын маягт, заавар арагачлалд гарсан өөрлөлтийн талаар Үндэсний статистикийн газраас нийт аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газар, статистикийн албадад семинар, удирдамж өгч ажиллав.

Өвөрхангай, Завхан, Ховд, Сүхбаатар, Өмнөговь Хөвсгөл аймагт сумдын Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга, Иргэдийн хурлын төлөөлөгчдийн нарийн бичгийн дарга, аймгийн төвийн багийн засаг дарга нарт зориулан мал тооллого, хүн амын статистик бүртгэлийн талаар семинар зохион байгуулсан нь үр дүнтэй боллоо.

Аймаг, сум, нийслэл, дүүргүүдэд мал тооллогын ажлыг удирдан зохион байгуулж явуулах комисс ажиллуулж, нэгдсэн семинар зөвлөгөөн орон нутагт зохиогдон, тооллогын үеэр сумдад хяналт шалгалтын групп томилон ажиллуулав. Тухайлбал Сүхбаатар, Төв аймагт хууль хяналт, мал эмнэлэг, үржлийн албаны хүмүүсийг оролцуулсан 5-8 хяналтын групп ажиллуулан ихэнх сумдад хяналт шалгалт хийлгэсэн байна.

1997 оны мал тооллогын ажлыг зохих заавар журмын дагуу явуулж, мал сүргийг тооллогод бүрэн хамруулах, тооллогын үнэн зөв байдлыг хангуулах талаар аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний тамгын газраас зориуд анхаарч, дэмжлэг тусалцаа үзүүлэн зохион байгуулсныг тэмдэглэж байна.

II. МАЛ ТЭЖЭЭВЭР АМЬТАДЫН ТОО, БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

II.1. Малын тоо, бүрэлдэхүүн, тархалт.

Малын тооны өсөлт. 1997 оны эцэст 31.3 сая мал тоологдсон нь 1996 оныхоос 6.8 хувь буюу 1992.2 мянган толгойгоор өслөө. Урьд оныхоос хонь 605.0 мянга, ямаа 1130.5 мянга, үхэр 136.5 мянга, адуу 122.7 мянгаар нэмэгдэж, харин тэмээ 2.5 мянгаар хорогдлоо.

Бодод шилжүүлснээр малын тоо урьд оныхоос 4.9 хувь буюу 497.6 мянгаар өссөн байна.

Малын тоо (мян.тол)

	1990	1992	1995	1996	1997	1999/1998	
						%	Зөрүү
Бодоор *	9071.5	8785.3	9868.2	10185.6	10683.2	104.9	497.6
Толгойн тоо	25856.9	25694.1	28572.3	29300.1	31292.3	106.8	1992.2
Тэмээ	537.5	415.2	367.5	3557.9	355.4	99.3	-2.5
Адуу	2262.0	2200.2	2648.4	2770.5	2893.2	104.4	122.7
Үхэр	2848.7	2819.2	3317.1	3476.3	3612.9	103.9	136.5
Хонь	15083.0	14657.0	13718.6	13560.6	14165.6	104.5	605.0
Ямаа	5125.7	5602.5	8520.7	9134.8	10265.3	112.4	1130.5

* Бодод шилжүүлэхдээ адуу, үхрийг нэг бод, тэмээг 1.5 бод, 6 хонь, 8 ямааг тус бүр нэг бод гэж тооцов.

18 аймаг урьд онд байсан малаа бодод шилжүүлснээр болон толгойн дүнгээр өсгөсний дотор Өмнөговь, Дундговь, Баянхонгор, Сүхбаатар, Баян-Өлгий аймаг таван төрөл дээр нь өсгөв.

1996 онд 79 сум малаа таван төрөл дээр нь өсгөсөн бол 1997 онд 125 сум малаа төрөл бүр дээр өсгөжээ.

Ховд, Орхон, Дархан-Уул аймаг, Улаанбаатар хотын малын тоо 0.4 – 0.8 хувь буюу 0.3 – 28.4 мянган толгойгоор хорогдсон байна.

Тэмээн сүргийн тоо 8 аймагт буулсны дотор Говь-Алтай, Ховд аймагт тус бүр 1.7 мянга, Дорноговь, Өвөрхангай аймагт 0.4-0.8 мянгаар цөөрсөн нь улсын хэмжээгээр тэмээний нийт тоо толгой буурахад голлон нөлөөлөв. (Хавсралт хүснэгтийн 4, 5- р хуудаснаас үзнэ үү. Цаашид хавсралт хүснэгтийн хуудасны дугаарыг заана)

Сүүлийн жилүүдэд малын тоо толгой нийт дүнгээрээ өсч байгаа боловч төрөл дотроо өсөлт жигд биш байна. Өнгөрсөн долоон жил буюу 1991 – 1997 онд манай улсын мал сүргийн тоо 5 жилд нь өсч, 21.0 хувь буюу 5.5 саяаар нэмэгджээ. Энэ өсөлтийн 5.1 сая буюу 95 хувийг нь ямаан сүргийн өсөлт эзэллэж байна. 1994 оноос эхлэн ямааны тоо жилд дунджаар нэг сая гаруй толгойгоор өсөх болов.

Сүүлийн 7 жилд малын өсөлтийг төрлөөр үзүүлбэл

	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Өссөн жилийн тоо	5	1	4	4	2	7
Буурсан жилийн тоо	2	6	3	3	5	-
1997 оныхоос өссөн хэмжээ (мян.тол)	5435.4		631.2	764.1		5139.6
1990 оныхоос буурсан хэмжээ (мян.тол)		-182.1			-917.4	

Өнгөрсөн долоон жилд малын өсөлтийг аймгаар авч үзвэл говийн бүсийнх илүүтэй өсчээ. Өмнөговь, Дундговь, Булган, Өвөрхангай, Баянхонгор аймгийн малын тоо жилд дунджаар 4.0-7.5 хувиар өссөн нь бусад аймгуудаас харьцангуй илүүтэй байна. Эдгээр аймгийн ямааны тоо 1.9-2.5 дахин нэмэгдсэн нь нийт малын өсөлтөд голлох үүрэг гүйцэтгэжээ.

Нийт малын тооны өсөлт, бууралтын хувиар аймгуудыг үзүүлбэл :

	1997\1996			
	Бодод шилжүүлснээр		Толгойн тоогоор	
	хувь	Зөрүү (мян.бод)	Хувь	Зөрүү (мян.тол)
1.Өмнөговь	110.5	43.4	114.2	187.6
2.Архангай	108.8	68.8	111.5	199.1
3.Сүхбаатар	108.7	37.0	108.9	92.2
4.Дундговь	108.3	47.2	109.8	180.9
5.Говьсүмбэр	108.3	3.0	106.4	7.0
6.Дорнод	107.7	20.7	110.6	63.0
7.Хэнтий	107.7	36.9	109.0	103.5
8.Төв	107.5	53.6	109.7	180.5
9.Хөвсгөл	106.7	56.4	108.9	175.4
10.Баянхонгор	106.6	42.8	108.7	194.9
11.Булган	106.4	33.1	108.9	107.3
12.Баян-Өлгий	105.8	23.3	108.1	113.5
13.Өвөрхангай	103.8	32.6	106.6	168.1
14.Дорноговь	103.4	11.4	104.4	40.6
15.Завхан	102.8	22.1	103.3	82.0
16.Увс	102.1	11.6	105.2	91.4
17.Сэлэнгэ	100.6	1.2	103.1	15.9
18.Говь-Алтай	97.8	-11.7	101.2	25.3
19.Ховд	96.3	-21.1	98.5	-28.4
20.Дархан-Уул	94.5	-3.1	99.8	-0.3
21.Улаанбаатар	93.5	-8.2	98.5	-4.6
22.Орхон	93.2	-3.4	97.7	-2.8

Манай орны түүхэнд 1997 онд хамгийн олон мал, тэрчлэн адуу, үхэр, ямаа тоологдов.

Малын тоо толгойн хүрсэн дээд хэмжээг үзүүлбэл:

	1918 оноос хойш		Жилийн эцэст тоолдог болсон 1961 оноос хойш	
	мян.тол	он	мян.тол	он
Бүгд	31292.3	1997	31292.3	1997
Тэмээ	895.3	1954	751.7	1961
Адуу	2893.2	1997	2893.2	1997
Үхэр	3612.9	1997	3612.9	1997
Хонь	15936.4	1941	15083.0	1990
Ямаа	10265.3	1997	10265.3	1997

1990 оноос хойш нийт сүрэгт тэмээ, хонины эзлэх хувийн жин жилээс жилд буурч байна.

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь

	1990	1992	1993	1994	1995	1996	1997
Тэмээ	2.1	1.6	1.5	1.4	1.3	1.2	1.1
Адуу	8.8	8.6	8.7	9.0	9.3	9.4	9.3
Үхэр	11.0	11.0	10.8	11.2	11.6	11.9	11.5
Хонь	58.3	57.0	54.7	51.4	48.0	46.3	45.3
Ямаа	19.8	21.8	24.3	27.0	29.8	31.2	32.8
Бүгд	100	100	100	100	100	100	100

Улсад нийт малын тоогоор Өвөрхангай, тэмээгээр Өмнөговь, адуугаар Төв, үхрээр Хөвсгөл, хониор Завхан, ямаагаар Баянхонгор аймгууд тэргүүн байранд байна. (Хавсралтын хуудасны дугаар 1)

Манай улс дэлхийн улс орнуудын дотор адуугаар 6 дугаар, тэмээгээр 11, ямаагаар 15, хониор 23, үхрээр 57 дугаар байранд орж байна.

Ази тивд адуугаар 2 дугаар, тэмээгээр 3, хонь, ямаагаар тус бүр 8, үхрээр 15 дугаар байранд орж байна.

Адуу, тэмээний тоогоор (мян.тол)

Улсын нэр	Адууны тоо	Улсын нэр	Тэмээний тоо
1.Хятад	10039	1.Сомали	6200
2.Мексик	6185	2.Судан	2903
3.Бразил	6300	3.Энэтхэг	1520
4.АНУ	6000	4.Пакистан	1119
5.Аргентин	3300	5.Мавритан	1087
6.Монгол	2893	6.Этиоп	1000
		7.Кени	810
		8.Чад	600
		9.Саудын араб	418
		10.Нигер	380
		11.Монгол	355

Тайлбар: Дэлхийн улсуудын малын тоог 1995 оноор авсан болно.

Манай улс дэлхийд нэг хүн амд ногдох адуу, ямаагаар тэргүүн байр, тэмээ, хониор 4-р байранд тус тус орж байна.

Нэг хүн амд ногдох малын тоогоор эхний байруудад ордог улс орнуудыг үзүүлбэл: (толгой)

Адуугаар		Тэмээгээр		Хониор		Ямаагаар	
1. Монгол	1.2	Сомали	0.7	Шинэ Зеланд	13.2	Монгол	4.3
2. Казахстан	0.1	Мавритан	0.5	Уругвай	7.1	Мавритан	1.6
3. Аргентин	0.09	Чад	0.18	Австрали	6.8	Сомали	1.4
4. Кыргызстан	0.07	Монгол	0.15	Монгол	6.0	Мали	0.7
5. Мексик	0.06	Судан	0.1	Казахстан	2.0	Судан	0.6

Хувийн (амины) малын тоо. 1997 онд улсын хэмжээгээр аминдаа малтай 279.7 мянган өрх тоологдсоны дотор 65.6 хувь буюу 183.6 мянга нь малчин өрх, 34.4 хувь буюу 96.1 мянга нь мал бүхий бусад иргэдийн өрх байна. Хувийн малын тоо 1990 онд нийт малын 31.9 хувь байснаа 1997 онд 94.4 хувийг эзлэх болов. 1997 онд хувийн малын тоо 29.5 саяд хүрч, өмнөх оныхоос 2.2 саяар нэмэгдэв.

Ямаа адууны 97.0-97.2 хувь, тэмээ, үхрийн 96.5-96.7 хувь, хонины 91.2 хувь нь хувийн аж ахуйд ногдох болжээ.

Хонины 94.2 хувь, бусад төрлийн малын 97.4 – 97.9 хувь нь хувийн аж ахуйд ногдох болжээ.

Өнгөрсөн онд бүх аймаг, хотын хувийн малын тоо урьд оныхоос өссөн байна.

Хувийн малын өсөлт, аймгаар (мян.тол)

	Толгойн тоо (мян.тол)					1997\1996	
	1990	1994	1995	1996	1997	Хувь	Зөрүү
Архангай	565.4	1570.2	1577.9	1697.8	1900.8	112.0	203.0
Баян-Өлгий	607.6	1126.8	1324.6	1381.3	1494.7	108.2	113.4
Баянхонгор	505.1	1903.8	2134.8	2155.2	2359.3	109.5	204.1
Булган	273.7	953.5	1018.6	1096.5	1210.0	110.4	113.5
Говь-Алтай	525.8	1911.5	2044.3	2038.7	2070.7	101.5	32.0
Дорноговь	253.0	711.3	776.5	817.2	867.4	106.1	50.2
Дорнод	169.4	503.3	466.9	483.8	549.6	113.6	65.8
Дундговь	438.6	1470.5	1660.8	1790.0	1970.5	110.1	180.5
Завхан	676.4	2176.2	2330.4	2408.3	2505.6	104.0	97.3
Өвөрхангай	801.4	2225.1	2465.3	2427.5	2611.8	107.6	184.3
Өмнөговь	303.8	1001.0	1159.6	1275.0	1458.5	114.4	183.5
Сүхбаатар	286.8	895.0	894.8	937.8	1042.5	111.2	104.7
Сэлэнгэ	123.1	298.5	314.0	331.4	371.1	112.0	39.7
Төв	512.3	1278.7	1420.8	1553.1	1747.2	112.5	194.1
Увс	550.1	1601.8	1657.0	1679.5	1780.7	106.0	101.2
Ховд	584.0	1771.6	1944.5	1842.3	1845.0	100.1	2.7
Хөвсгөл	605.9	1715.4	1789.1	1923.6	2102.1	109.3	178.5
Хэнтий	308.8	952.5	959.7	1004.4	1103.3	109.8	98.9
Дархан-Уул	38.0	101.0	102.4	102.8	103.8	101.0	1.0
Улаанбаатар	77.5	229.5	250.2	254.7	256.0	100.5	1.3
Орхон	19.3	81.3	95.4	96.7	99.3	102.7	2.6
Говьсүмбэр	16.9	48.7	59.6	67.6	79.1	117.0	11.5
ДҮН	8242.9	24527.2	26447.2	27365.2	29529.0	107.9	2163.8

Хувийн аж ахуйд байгаа малын бүтцийг авч үзвэл хонь 43.7 хувь, ямаа 33.8, үхэр 11.8, адуу 9.5, тэмээ 1.2 хувийг эзлэж байна.

Хувийн аж ахуйн мал, төрлөөр (мян.тол)

	Малтай өрхийн тоо	Бүгд	Ү Ү Н Э Э С				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
1990	262.3	8242.9	88.2	1108.1	1457.5	3684.7	1904.4
1991	288.9	14002.6	186.3	1492.1	1896.6	7209.4	3218.2
1992	301.5	18081.1	253.7	1728.0	2237.4	9589.1	4272.9
1993	289.7	22565.2	335.0	2026.8	2503.5	11902.0	5797.9
1994	289.2	24527.2	343.3	2279.0	2811.8	12133.8	6959.3
1995	283.9	26447.2	349.7	2532.0	3140.4	12194.1	8231.0
1996	278.3	27365.2	342.6	2670.6	3323.4	12184.6	8844.0
1997	279.7	29529.0	343.8	2807.4	3485.3	12912.0	9980.5

Иргэдийн хувийн малын бүлэглэлтээс үзвэл 51-200 малтай өрх бусад бүлгээс харьцангуй олонхи нь буюу 46.1 хувийг эзлэж байна.

100 хүртэл малтай ядуу, ядуувтар өрх нийт малтай өрхийн 58.4 хувийг эзлэж байна.Тэрчлэн малтай өрх бүрийн дөрөвний нэг нь 101 – 200 толгойгоос хэтрэхгүй малтай байна.

1996 онд 50 хүртэл малтай өрх нийт мал бүхий өрхийн 44.7 хувийг эзлэж байсан бол 1997 онд 39.8 хувийг эзлэх болж буурлаа. Энэ хугацаанд 51-200 малтай өрхийн эзлэх хувийн жин 4.1 пунктээр нэмэгдсэн байна. 1000 ба дээш малтай өрх 1994 онд 144 байсан бол 1997 онд 599 болж 4.2 дахин нэмэгджээ.

Иргэдийн хувийн малын бүлэглэлт

	Малтай өрхийн тоо		Дүнд эзлэх хувь		Малын тоо	
	1996	1997	1996	1997	1996	1997
10хүртэл малтай	39778	35530	14.3	12.7	233.1	200.9
11-30 малтай	47080	41009	16.9	14.7	969.0	832.1
31-50 малтай	37462	34784	13.5	12.4	1517.6	1409.5
51-100 малтай	61464	63774	22.1	22.8	4524.7	4796.6
101-200 малтай	55383	65282	19.9	23.3	7838.5	9085.7
201-500 малтай	32983	34539	11.8	12.4	9410.5	9855.3
501-999 малтай	3678	4137	1.3	1.5	2298.3	2632.1
1000-1499 малтай	445	531	0.2	0.2	496.8	594.7
1500-2000 малтай	32	54	0	0	53.2	89.7
2001-ээс дээш малтай	10	14	0	0	23.1	32.2
ДҮН	278315	279654	100	100	27365.2	29529.0

Одоо 50 хүртэл малтай өрхүүд үндсэндээ дөрвөн хошуу малтай байгаагийн дотор 10 хүртэл малтай өрх дунджаар 1 адуу, 3 үхэр, 2 бог малтай байна.

Нэг өрхөд ногдох хувийн малын бүлэглэлт 1997 оны байдлаар (толгой)

	Бүгд	Ү Ү Н Э Э С				
		тэмээ	Адуу	үхэр	Хонь	цмаа
10хүртэл малтай	5.7	0.0	0.8	2.8	1.2	0.9
11-30 малтай	20.3	0.1	2.7	5.9	6.3	5.3
31-50 малтай	40.5	0.2	4.9	8.6	14.8	12.0
51-100 малтай	75.2	0.5	8.3	12.0	30.2	24.2
101-200 малтай	139.2	1.4	13.2	15.8	60.9	47.9
201-500 малтай	285.3	4.5	24.7	23.6	129.5	103.0
501-999 малтай	636.2	10.9	49.9	44.4	317.9	213.1
1000-1499 малтай	1119.9	14.7	86.8	72.2	627.5	318.7
1500-2000 малтай	1661.4	19.6	96.4	96.1	979.6	469.7
2001-с дээш малтай	2298.0	12.3	175.4	156.5	1619.4	334.4
ДҮН	105.6	1.2	10.0	12.5	46.2	35.7

Улсын дунджаар малтай нэг өрхөд (бодод шилжүүлснээр) 37 бод буюу 106 толгой мал ногдож байхад Дундговь, Өмнөговь, Говь-Алтай аймагт 40-59 бод буюу 140 – 194 толгой мал ногдож байна.

Малтай нэг өрхөд ногдох хувийн малын тоо

	Бодод шилжүүлснээр			Толгойн тоогоор		
	1995	1996	1997	1995	1996	1997
Архангай	32.1	34.9	37.8	72	77	85
Баян-Өлгий	26.1	27.2	28.4	92	95	101
Баянхонгор	36.9	37.1	39.1	129	127	137
Булган	39.5	41.0	43.4	89	93	101
Говь-Алтай	41.1	41.1	39.5	162	162	161
Дорноговь	45.1	47.7	51.0	122	129	140
Дорнод	24.4	27.2	28.0	50	57	60
Дундговь	51.8	55.3	59.1	169	179	194
Завхан	39.2	41.9	43.0	122	129	133
Өвөрхангай	35.4	35.5	36.5	105	105	111
Өмнөговь	45.7	49.1	53.2	141	155	174
Сүхбаатар	37.2	39.4	42.3	88	95	103
Сэлэнгэ	11.8	12.9	14.0	27	30	34
Төв	30.0	34.1	37.4	74	84	95
Увс	28.6	29.9	31.2	88	93	100
Ховд	38.3	38.0	36.8	131	127	126
Хөвсгөл	33.3	35.8	37.8	78	83	90
Хэнтий	34.5	37.1	40.3	78	84	92
Дархан-Уул	9.3	10.4	10.4	21	24	25
Улаанбаатар	9.9	11.2	11.5	23	26	28
Орхон	12.6	14.5	17.3	30	33	42
Говьсүмбэр	19.9	22.3	25.5	52	58	67
ДҮН	32.6	34.7	36.5	93	98	106

Хээлтэгч мал. 1997 оны эцэст 13095.5 мянган хээлтэгч мал тоологдсон нь урьд оныхоос 1323.7 мянгаар өссөний дотор эм хонь 526.5 мянга, гүү 46.2 мянга, үнээ 155.4 мянга, эм ямаа 596.6 мянгаар нэмэгдэж, ингэ 1.0 мянгаар буурсан байна.

Хээлтэгч малын тоо (мян.тол)

	1990	1994	1995	1996	1997	1997\1996	
						Хувь	Зөрүү
Ингэ	140.9	100.8	101.3	98.7	97.7	99.1	-1.0
Гүү	563.5	650.3	707.1	737.0	783.2	106.3	46.2
Үнээ	1127.1	1170.6	1177.8	1215.4	1370.8	112.8	155.4
Эм хонь	7786.1	6320.1	5948.3	5844.1	6370.6	109.0	526.5
Эм ямаа	2425.7	3271.5	3607.7	3876.6	4473.2	115.4	596.6
ДҮН	12043.3	11513.3	11542.2	11771.8	13095.5	111.2	1323.7

Бүх аймаг, нийслэл хот хээлтэгч малынхаа тоог урьд оныхоос өсгөсөн байна. (Хавсралтын хуудасны дугаар 14 – 16)

Бүх хээлтэгч малын 93.5 хувь, үүний дотор ингэний 96.7, гүүний 97.1, үнээний 96.0, эм хонины 90.0, эм ямааны 97.1 хувь нь хувийн аж ахуйд байна.

1961 оноос хойш олон хээлтэгч мал тоологдсон жил

	мян.тол	он		мян.тол	Он
Ингэ	226.9	1961	Эм хонь	7786.1	1990
Гүү	783.2	1997	Эм ямаа	4473.2	1997
Үнээ	1370.8	1997			

Төл бойжилт. 1997 онд гарсан төлийн 96.6 хувь буюу 9537.3 мянган төл бойжуулав. Бойжсон төлийн тоо өмнөх оныхоос 489.8 мянгаар нэмэгджээ. Бойжуулсан нийт төлөөс 7.3 мянгыг каракуль арьсанд нядалсан байна.

Төл бойжилт (мян.тол)

	Бүгд	Ү Ү Н Э Э С					1997-1996 зөрүү
		ботго	унага	тугал	хурга	ишиг	
Гарсан	10083.4	42.7	501.6	977.0	5195.2	3366.9	309.0
Бойжсон	9537.3	39.3	471.9	944.6	4946.4	3135.1	489.8
Хорогдсон	546.1	3.4	29.7	32.4	248.8	231.8	-232.0
Бойжилтын хувь	94.6	92.1	94.1	96.7	95.2	93.1	2.0

Бойжуулсан төл (мян.тол)

	1991-1995 оны дундаж	1991	1993	1994	1995	1996	1997
Ботго	42.3	52.9	35.6	36.7	40.5	37.0	39.3
Унага	357.4	343.8	289.8	387.6	451.2	467.2	471.9
Тугал	778.1	762.5	669.3	812.9	920.4	918.1	944.6
Хурга	5431.3	6468.8	4906.6	5085.2	4969.2	4873.3	4946.4
Ишиг	2141.5	1983.7	1860.5	2307.6	2631.1	2751.9	3135.1
Бүгд	8750.6	9611.7	7761.8	8630.0	9012.4	9047.5	9537.3

1997 онд хамгийн олон ишиг, тугал, унага бойжуулан авлаа.

1961 оноос хойш хамгийн олон төл бойжуулсан жил

	мян.төл	он		мян.төл	Он
Бүгд	9673.3	1989	Тугал	944.6	1997
Ботго	74.4	1975	Хурга	6569.6	1989
Унага	471.9	1997	Ишиг	3135.1	1997

1997 онд 100 эхээс бойжуулсан төлийг өмнөх оныхтой зэрэгцүүлж үзвэл ишиг 5, хурга, ботго тус бүр 3-аар их, унага 2-оор бага байна.

100 эхээс бойжуулсан төл

	1991-1995 оны дундаж	1991	1993	1994	1995	1996	1997
Ботго	36	38	32	37	40	37	40
Унага	61	61	51	67	69	66	64
Тугал	72	68	65	78	79	78	78
Хурга	77	83	69	79	79	82	85
Ишиг	78	82	70	80	80	76	81
Бүгд	76	80	68	78	78	78	81

100 хээлтэгчээс Архангай, Баян-Өлгий, Булган, Сүхбаатар, Өвөрхангай, аймаг 87-91 төл бойжуулсан байхад Дархан-Уул, Сэлэнгэ, Ховд аймаг, Улаанбаатар хот 63-68 төл бойжуулжээ. (Хавсралтын хуудасны дугаар 18)

Том малын зүй бус хорогдол. 1997 оны эхний малын 2.1 хувьтай тэнцэх 617.7 мянган том мал зүй бусаар хорогдсон нь урьд оныхоос 30.9 мянгаар их, 1991-1995 оны дунджаас 355.3 мянгаар бага байна.

Том малын зүй бус хорогдол

	1991-1995 оны дундаж	1991	1993	1994	1995	1996	1997
Тэмээ	16.6	20.8	23.8	9.5	7.5	8.4	6.0
Адуу	76.7	72.7	140.4	41.6	48.1	53.2	45.1
Үхэр	132.9	104.6	278.9	78.3	84.6	79.8	110.6
Хонь	579.1	624.1	927.9	423.8	403.2	288.7	278.9
Ямаа	167.7	156.0	281.1	136.8	130.5	156.7	177.1
Бүгд	973.0	978.2	1652.1	690.0	673.9	586.8	617.7

Оны эхний малд зүй бус хорогдолын эзлэх хувь

	1991-1995 оны дундаж	1991	1993	1994	1995	1996	1997
Тэмээ	3.7	3.9	5.7	2.6	2.0	2.3	1.7
Адуу	3.4	3.2	6.4	1.9	2.0	2.0	1.6
Үхэр	4.7	3.7	9.9	2.9	2.8	2.4	3.2
Хонь	4.0	4.1	6.3	3.1	2.9	2.1	2.1
Ямаа	2.9	3.0	5.0	2.2	1.8	1.8	1.9
Бүгд	3.8	3.8	6.4	2.7	2.5	2.1	2.1

1996-1997 оны өвөл зарим сумд нь цас ихтэй, зудын байдалтай өвөлжсөн Ховд, Завхан, Баян-Өлгий, Сүхбаатар, Дорноговь, Говь-Алтай, Говьсүмбэр аймгийн малын зүй бусын хорогдол урьд оныхоос 1.4-3.9 дахин нэмэгдэж, дээрхи аймгуудын дүнгээр 339.2 мянган толгой мал зүй бусаар хорогдсон нь

улсын хэмжээний нийт хорогдолын 54.9 хувийг эзлэж байна. (Хавсралтын хуудасны дугаар 19)

Том малын зүй бус хорогдолын 29.6 хувь буюу 182.6 мянга нь өвчнөөр, 33.6 хувь буюу 207.3 мянга нь гэнэтийн аюулаар хорогдов.

1961 оноос хойш малын зүй бус хорогдол хамгийн бага болон их гарсан жил

	Хамгийн бага хорогдол гарсан		Хамгийн их хорогдол гарсан	
	мян.тол	он	мян.тол	он
Бүгд	510.3	1989	2663.8	1968
Тэмээ	6.0	1997	66.3	1966
Адуу	41.6	1994	235.3	1968
Үхэр	52.3	1974	278.9	1993
Хонь	278.9	1997	1606.3	1968
Ямаа	89.3	1989	574.8	1968

Малын хээл хаялт, сувайралт. 1997 оны эхний хээлтэгч малын 13.8 хувь буюу 1582.7 мянга нь хээл хаяж, сувайрсан нь 1991-1995 оны дунджаас 2.5 хувь буюу 39.3 мянга, өмнөх оныхоос 19.5 хувь буюу 258.4 мянгаар нэмэгдсэн байна.

Сэлэнгэ, Дархан-Уул, Дорноговь, Орхон аймаг, Улаанбаатар хотод оны эхний хээлтэгч малынхаа 21.5-28.4 хувиас дээрх шалтгаанаар төл авч чадсангүй. (Хавсралтын хуудасны дугаар 20-22)

Дээрхи аймгууд болон Улаанбаатар хот 1997 онд 100 эхээс улсын дунджаас 5-15 толгойгоор бага төл бойжуулсан нь хээл хаялт, сувайрлалт их гарснаас голлон шалтгаалсан байна.

Хээл хаяж, сувайрсан эх малын тоо (мян.тол)

	Төл өгөөгүй хээлтэгч мал бүгд				үүнээс: сувайрсан		
	1991-1995 дундаж	1996	1997	1997\1996 хувь	1990-1995 дундаж	1996	1997
Ингэ	14.1	9.4	11.1	118.1	11.3	7.4	8.3
Гүү	182.1	173.0	219.6	126.9	138.7	131.5	159.0
Үнээ	236.3	192.7	223.5	116.0	189.0	153.5	170.6
Эм хонь	767.0	512.0	604.5	118.1	538.6	351.9	406.0
Эм ямаа	343.9	437.2	524.0	119.9	205.8	229.2	298.7
ДҮН	1543.4	1324.3	1582.7	119.5	1083.4	873.5	1042.6

Нийт хээлтэгчид хээл хаяж, сувайрсан эх малын эзлэх хувь

	Бүгд			үүнээс: сувайрсан		
	1990-1995	1996	1997	1990-1995	1996	1997
Ингэ	12.1	9.2	11.2	9.7	7.3	8.4
Гүү	31.3	24.5	29.8	23.8	18.6	21.6
Үнээ	21.8	16.4	18.4	17.4	13.0	14.0
Эм хонь	10.9	8.6	10.3	7.7	5.9	6.9
Эм ямаа	12.7	12.1	13.5	7.6	6.4	7.7
ДҮН	13.4	11.5	13.4	9.3	7.6	8.9

1961 оноос хойш эх малын хээл хаялт, сувайралт хамгийн бага болон их гарсан жил

	Хамгийн бага		Хамгийн их	
	мян.тол	он	мян.тол	он
Бүгд	645.8	1963	1907.9	1977
Ингэ	9.4	1996	26.4	1973
Гүү	152.3	1995	333.6	1973
Үнээ	106.1	1962	326.0	1981
Эм хонь	190.6	1962	913.0	1993
Эм ямаа	124.7	1963	558.1	1968

Хээлтээгч, хээлтүүлэгчийн тохироо. Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой байхад одоо улсын дунджаар 61 эм хонь, 59 эм ямаа ногдож, хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо алдагдсан хэвээр байна. Энэ байдал эх малын сувайралт нэмэгдүүлэхэд нөлөөлж, мал өсгөх багагүй нөөц бололцоог алдаж байна.

1990 онд улсын хэмжээгээр 7786.1 мянган эм хонь байхад үржлийн ажилд 242.7 мянган хуц ашиглагдаж байсан бол 1996 онд 6370.6 мянган эм хонинд 104.2 мянган хуцтай байна. 1990 онд 20.9 мянган хуц шинээр нэмж тавьж байсан бол 1996-1997 онд 2.5-3.1 мянгыг шинээр нэмж тавьжээ.

Хээлтүүлэгч малын тоо (мян.тол)

	Бүгд				үүнээс: шинээр тавьсан		
	1990	1996	1997	1997\1996	1990	1996	1997
Буур	4.1	4.7	4.8	102.1	66.0	64	54
Азрага	70.5	104.8	112.3	107.2	0.9	1.0	1.2
Бух	59.5	58.3	60.3	103.4	2.5	1.1	1.3
Хуц	242.9	102.0	104.2	102.2	20.9	3.1	2.5
Ухна	73.6	72.2	75.3	104.3	7.5	2.5	1.5
ДҮН	450.6	342.0	356.9	104.4	31.9	7.7	6.6

Нэг хээлтүүлэгчид ногдох хээлтэгч малын тоо

	Үржлийн норм	1990	1996	1997	Хувийн 1990	аж 1996	ахуйд 1997
Ингэ	20-25	34	21	20	34	20	21
Гүү	12-15	8	7	7	6	7	7
Үнээ	35-45	19	21	23	21	21	23
Эм хонь	25-30	32	57	61	146	58	61
Эм ямаа	25-30	33	54	59	100	54	60

Говь-Алтай, Баянхонгор, Ховд, Өмнөговь аймагт ухна, Архангай, Төв, Говь-Алтай, Булган, Сэлэнгэ, Орхон аймагт хуц их дутагдалтай байна. (Хавсралтын хуудасны дугаар 23)

Малын хэрэглээний зарлага. Оны эхний нийт малын 23.6 хувьтай тэнцэх 6920.0 мянган малыг хүнсний хэрэгцээнд зарцуулсан нь 1996 оныхоос 806.3 мянган толгойгоор буурсан байна. 1996 оны өвөл зарим бүс нутагт цаг агаар хүндэрсэнтэй холбогдон мал нядалгаа нэмэгдсэн нь улмаар 1997 онд нөөцлөгдсөн малын хэрэглээний зарлага буурахад нөлөөлөв.

1999 онд оны эхний тэмээний 10 хувь, адууны 11 хувь, үхэр, ямааны 20.0 хувь, хонины 30 шахам хувийг хүнсний хэрэглээнд зарцуулжээ.

Сүүлийн жилүүдэд хонины хэрэглээ анх удаагаа 1997 онд мэдэгдэхүйц буурснаас тоо толгой нь өслөө. Одоо тэмээний хүнсний хэрэглээ сүргийн онцлог нөхөн үржлийн өсөлтөөс нь ямагт хэтэрч байна. Үүнийг уламжлалт хэрэглээнд нь ойртуулж 7-8 хувиас хэтрүүлэхгүй байвал тэмээ өсөхөөр байна. Говийн бүсийн аймгуудад тэмээний махны хэрэглээг ямааны махаар нөхөх боломж ихтэй болов. Тэмээ их хорогдож байгаа Говь-Алтай, Ховд, Дорноговь, Өвөрхангай аймагт оны эхэнд байсан тэмээнийхээ 11-13 хувийг хүнсэнд хэрэглэсэн байхад ямааны хувьд 21-22 хувийг л хэрэглэжээ. (Хавсралтын хуудасны дугаар 24)

Малын нийт хэрэглээний зарлага. (мян.тол)

	1986- 1990 оны дундаж	1991- 1995 оны дундаж	1991	1994	1995	1996	1997
Бүгд	7559.8	7219.3	8930.5	6297.6	6567.3	7726.3	6920.0
Тэмээ	38.9	59.4	93.6	28.6	31.6	38.3	35.8
Адуу	201.7	203.5	273.8	127.5	163.5	291.9	304.1
Үхэр	544.3	551.5	684.6	459.9	523.9	679.0	697.4
Хонь	5311.3	5110.1	6174.6	4645.0	4627.1	4736.0	4055.1
Ямаа	1463.6	1294.8	1703.9	1036.6	1221.2	1981.1	1827.6

Оны эхний малд эзлэх хувь

	1986-1990 оны дундаж	1991-1995 оны дундаж	1991	1994	1995	1996	1997
Бүгд	32.7	28.2	34.5	25.0	24.5	27.0	23.6
Тэмээ	7.0	13.2	17.4	7.8	8.6	10.4	10.0
Адуу	9.8	9.0	12.1	5.8	6.8	11.0	11.0
Үхэр	21.5	19.4	24.0	16.8	17.4	20.5	20.1
Хонь	39.4	35.4	40.9	33.7	33.6	34.5	29.9
Ямаа	32.5	22.7	33.2	17.0	16.9	23.3	20.0

Сүргийн бүтэц. Нийт сүргийн 34.0 хувь нь төл, өсвөр насны, 41.9 хувь нь хээлтэгч, 23.0 хувь нь нас гүйцсэн эр мал, 1.1 хувь нь хээлтүүлэгч мал байна.

Сүрэгт хээлтэгчийн эзлэх хувь урьд оныхоос 1.7 пунктаар өссөний дотор ингэнээс бусад эх малын хувийн жин нэмэгдэв.

Сүргийн бүтэц (хувиар)

	Төл, өсвөр насны			Нас гүйцсэн эр		
	1990	1996	1997	1990	1996	1997
Тэмээ	32.7	29.3	30.0	36.1	41.8	41.1
Адуу	37.6	36.3	36.1	34.4	33.3	33.0
Үхэр	49.8	51.8	44.9	8.5	11.6	15.5
Хонь	38.4	34.0	33.9	8.5	22.1	20.4
Ямаа	35.2	28.8	29.9	16.2	28.0	25.8
ДҮН	38.8	34.6	34.0	13.0	24.0	23.0

үргэлжлэл

	Хээлтэгч			Хээлтүүлэгч		
	1990	1996	1997	1990	1996	1997
Тэмээ	26.2	27.6	27.5	0.8	1.3	1.4
Адуу	24.9	26.6	27.1	3.1	3.8	3.9
Үхэр	39.6	34.9	37.9	2.1	1.7	1.7
Хонь	51.6	43.1	45.0	1.5	0.8	0.7
Ямаа	47.3	42.4	43.6	1.3	0.8	0.7
ДҮН	46.6	40.2	41.9	1.6	1.2	1.1

Сүүлийн жилүүдэд сүргийн бүтцэд томоохон өөрчлөлт гарлаа. 1997 онд нас гүйцсэн эр малын тоо 7.2 сая толгойд хүрсэн нь 1990 оныхоос 2.2 дахин буюу 3.9 сая толгойгоор өссөн байна.

Энэ хугацаанд эр ямааны тоо 3.2 дахин, эр үхэр, хонины тоо 2.2-2.3 дахин нэмэгдэж, нийт сүрэгт 8.5-16.2 хувийг эзлэж байсан бол 15.5-25.8 хувийг эзлэх болов.

Нас гүйцсэн эр малын тоо (мян.тол)

	1990	1995	1996	1997	1997\1990	
					Хувь	Зөрүү
Ат	193.8	154.1	149.6	146.2	75.4	-47.6
Морь	778.2	900.1	922.3	954.2	122.6	176.0
Шар	243.4	391.1	402.4	558.4	229.4	315.0
Эр хонь	1286.4	2921.1	2998.9	2886.8	224.4	1600.4
Эр ямаа	831.8	2275.7	2556.8	2645.2	318.0	1813.4
ДҮН	3333.6	6642.8	7030.0	7190.8	215.7	3857.2

Нас гүйцсэн эр малын тоо өмнөх оныхоос 160.8 мянгаар нэмэгдсэний дотор ямаа 88.4 мянга, адуу 31.9 мянга, үхэр 156.0 мянгаар өсч, хонь, 112.1 мянга, тэмээ 3.4 мянгаар буурлаа.

Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал. 1997 оны эцэст цэвэр үүлдрийн 753.6 мянга, эрлийз 1096.8 мянга, нутгийн шилдэг омгийн 762.7 мянган мал тоологдов. Цэвэр үүлдрийн мал 1996 оныхоос 2.3 хувь буюу 16.6 мянга, эрлийз 14.2 хувь буюу 136.1 мянга, нутгийн шилдэг омгийн мал 9.7хувь буюу 67.7мянгаар нэмэгдэв. (Хавсралт хуудасны дугаар 25,26)

1997 онд тоологдсон нийт үхрийн 4.9 хувь, хонины 9.6 хувь, ямааны 3.0 хувийг цэвэр, эрлийз мал эзлэж байна. Нийт цэвэр, эрлийз малын 87.3 хувь хувийн аж ахуйд, 12.7 хувь нь хөдөө аж ахуйн компани, хоршоо, улсын үйлдвэрийн газар, бусад байгууллагад ногдож байна.

Нутгийн шилдэг омгийн 2.9 мянган тэмээ, 7.7 мянган адуу, 3.9 мянган үхэр, 568.0 мянган хонь, 180.2 мянган ямаа тоологдлоо.

Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн
малын тоо, төрлөөр (мян.тол)

	1994	1995	1996	1997	1997\1996	
					хувь	зөрүү
1.Цэвэр үүлдрийн бүх мал	338.6	756.1	737.0	753.6	102.3	16.6
үхэр	39.3	51.4	53.5	50.2	93.8	-3.3
хонь	226.6	626.8	608.1	612.0	100.6	3.9
ямаа	72.7	77.9	75.4	91.4	121.2	16.0
2. Эрлийз	583.0	900.4	960.7	1096.8	114.2	136.1
үхэр	94.4	112.8	115.9	125.7	108.5	9.8
хонь	348.9	600.5	654.7	751.2	114.7	96.5
ямаа	139.7	187.1	190.1	219.9	115.7	29.8
3.Нутгийн шилдэг омгийн	846.1	614.0	695.0	762.7	109.7	67.7
үхэр	25.5	3.1	3.3	3.9	118.2	0.6
хонь	770.0	536.7	555.0	568.0	102.3	13.0
ямаа	50.6	65.2	124.9	180.2	144.3	55.3
тэмээ		2.0	4.3	2.9	67.4	-1.4
адуу		7.0	7.5	7.7	102.7	0.2

Цэвэр үүлдэр, эрлийз малын тоо, аж ахуйн салбараар. (мян.тол)

	Нийт цэвэр, эрлийз мал		Үхэр		Хонь		Ямаа	
	1996	1997	1996	1997	1996	1997	1996	1997
Хувийн аж ахуй	1399.4	1615.6	118.7	138.4	1026.5	1171.4	254.2	305.8
Бусад	298.3	234.8	50.7	37.5	236.3	191.8	11.3	5.5
ДҮН	1697.7	1850.4	169.4	175.9	1262.8	1363.2	265.5	311.3
Салбаруудын эзлэх хувийн жин								
Хувийн аж ахуй	82.4	87.3	70.1	78.7	81.3	85.9	95.7	98.2
Бусад	17.6	12.7	19.9	21.3	18.7	14.1	4.3	1.8
Дүн	100	100	100	100	100	100	100	100

Нийт малд цэвэр үүлдрийн болон эрлийз малын эзлэх хувь

	Үхэр		Хонь		Ямаа	
	1996	1997	1996	1997	1996	1997
Бүгд	4.9	4.9	9.3	9.6	2.9	3.0
цэвэр	1.5	1.4	4.5	4.3	0.8	0.9
эрлийз	3.3	3.5	4.8	5.3	2.1	2.1
Хувийн аж ахуй	3.5	4.0	8.4	9.1	2.9	3.1
цэвэр	0.6	0.8	3.9	3.8	0.8	0.9
эрлийз	2.9	3.2	4.5	5.3	2.1	2.2
ХАА-н газрууд	60.5	56.8	33.1	29.0	9.4	2.1
цэвэр	39.8	36.9	20.6	19.5	3.2	0.0
эрлийз	20.7	19.9	12.5	9.5	6.2	2.1

1997 онд цэвэр үүлдрийн хээлтэгч 361.9 мянга, эрлийз үүлдрийн 524.9 мянган хээлтэгч мал тоологдов. Цэвэр үүлдрийн болон эрлийз малд үнээ 39.7 хувь, эм хонь 49.5 хувь, эм ямаа 45.7 хувийг эзлэж байна.

Цэвэр үүлдрийн болон эрлийз хээлтэгч малын тоо (мян.тол)

	1994	1995	1996	1997	1997\1996	
					Хувь	Зөрүү
1.Цэвэр үүлдрийн бүх мал	178.4	375.4	358.6	361.9	100.9	3.3
Үнээ	20.7	22.3	22.8	20.7	90.8	-2.1
Эм хонь	118.8	312.9	297.5	296.7	99.7	-0.8
Эм ямаа	38.9	40.2	38.3	44.5	116.2	6.2
2.Эрлийз үүлдрийн	297.6	425.9	449.6	524.9	116.7	75.3
Үнээ	45.1	47.7	45.5	49.2	108.1	3.7
Эм хонь	179.8	288.2	314.9	378.0	120.0	63.1
Эм ямаа	72.7	90.0	89.2	97.7	109.5	8.5

Цэвэр үүлдрийн болон эрлийз малын хээлтэгчийн эзлэх хувь

	Үнээ		Эм хонь		Эм ямаа	
	1996	1997	1996	1997	1996	1997
Бүгд	40.3	39.7	48.5	49.5	48.0	45.7
цэвэр	42.6	41.3	48.9	48.5	50.8	48.7
эрлийз	39.3	39.1	48.1	50.3	46.9	44.4
Хувийн аж ахуй						
цэвэр	38.9	38.7	46.9	48.3	47.7	45.5
эрлийз	40.6	40.3	46.5	46.0	49.8	48.3
ХАА-н газрууд						
цэвэр	38.6	38.3	47.2	50.0	46.9	44.4
эрлийз	43.7	43.9	56.2	56.9	45.8	44.8
цэвэр	43.8	42.4	57.4	58.9	45.0	-
эрлийз	43.5	46.8	54.2	52.8	46.2	44.8

II.2. Тэжээвэр амьтад.

1997 оны эцэст 20.8 мянган гахай, 65.1 мянган шувуу, 619 цаа буга, 953 илжиг, 977 бүл зөгий тоологдов. 1996 оныхоос гахайн тоо 1.7 мянга, шувууны тоо 7.1 мянгаар өссөн байна.

Тэжээвэр амьтад, тэдгээрийг өсгөж, үржүүлдэг өрх, аж ахуйн тоо

	1990	1993	1995	1996	1997	1997\1996
Гахай (мян.тол)	134.7	28.6	23.5	19.1	20.8	109.1
Шувуу (мян.тол)	326.2	131.6	99.3	58.0	65.1	112.1
Цаа буга	3231	141.5	900	668	619	92.7
Илжиг, луус	1018	874	913	1064	953	89.6
Зөгий бүл	4768	1237	1165	1075	977	90.9
Туулай	7179	142	118	122	105	86.1
Үнэг	1251	1060	568	180	50	27.8
Булга	9691	4571	180	-	-	-
Гахайтай өрхийн тоо (мян)	15.7	5.4	4.2	3.4	2.9	83.3
Шувуутай өрхийн тоо (мян)	1.3	1.8	2.2	1.6	2.1	125.6
Гахай өсгөж үржүүлдэг аж ахуй, байгууллагын тоо	845	148	111	90	60	66.7
Шувуу өсгөж үржүүлдэг аж ахуй, байгууллагын тоо	150	33	25	17	7	41.2

Нийт гахайн тоо 1996 оныхоос 8 аймагт өссөний дотор Орхон, Дорноговь аймагт 2.2-17.6 дахин, Улаанбаатар хот, Сэлэнгэ, Дорнод аймагт 7.1-24.2 хувиар өсчээ.

Шувууны тоо Увс, Дархан-Уул, Орхон, Төв аймаг, Улаанбаатар хотоос бусад аймагт буурсан байна. (Хавсралтын хуудасны дугаар 27– 29)

1997 онд аминдаа гахайтай өрх 2.9 мянга, шувуутай өрх 2.1 мянга болсон нь 1996 оныхоос гахайтай өрх 571-ээр цөөрч, шувуутай өрх 420-р өссөн байна.

Одоо нийт гахайны 81.7 хувь, шувууны 31 хувь хувийн аж ахуйд байна.

Гахай, шувууны тоо, өмчийн төрлөөр (мян.тол)

	Гахай				Үндсэн мэгж			
	1996	1997	1997\1996	Хувийн жин	1996	1997	1997\1996	Хувийн жин
Дүн	19.1	20.8	108.9	100.0	5.6	5.64	100.4	100.0
Үүнээс: хувийн	15.3	17.0	111.1	81.7	4.6	5.1	109.3	89.4

үргэлжлэл

	Шувуу				Өндөглөгч			
	1996	1997	1997\1996	Хувийн жин	1996	1997	1997\1996	Хувийн жин
Дүн	58.0	65.1	112.2	100.0	27.5	59.6	216.7	100.0
Үүнээс: хувийн	15.5	20.2	130.3	31.0	9.7	14.8	152.6	24.8

II.3. Малын бэлчээр , тэжээлийн хүрэлцээ, хангамж

Бэлчээрийн хүрэлцээ. Газар зохион байгуулах албаны 1997 оны тайлангаар манай улсын бэлчээр, хадлангийн талбайг 127.6 сая га гэж тогтоосон нь 1990 оныхоос 2.7 хувь буюу 3.3 сая га-гаар нэмэгджээ. Энэ хугацаанд малын тоо хонин толгойд шилжүүлснээр 67.1 сая болж 23.0 хувь буюу 12.5 сая толгойгоор өссөн байна.

Малын тоо толгой өссөнтэй холбогдон 100 га бэлчээр, хадлангийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо 1989 онд 43 байсан бол 1997 онд 53 болж нэмэгдэв.

Одоо 100 га бэлчээр, хадлангийн талбайд Орхон аймагт 576 толгой, Улаанбаатарт 251, Дархан-Уул, Архангай, Хөвсгөл, Булган аймагт 101-162 толгой, (хонин толгойд шилжүүлсэн) мал ногдож байгаа нь аймгууд дотроос бэлчээрийн ачааллын хувьд хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

Өнгөрсөн найман жилд ихэнх аймгийн бэлчээрт ногдох мал нэмэгдсэний дотор Орхон, Төв, Өмнөговь, Архангай, Дархан-Уул аймагт бэлчээрийн хүрэлцээ 1.5-2.6 дахин багасчээ. Харин 1989 оныхоос Дорнод аймгийн мал хорогдсон, Улаанбаатар хотод бэлчээр нэмэгдснээс 100 га бэлчээр хадлангийн талбайд ногдох малын тоо буурсан байна.

Бэлчээрийн хүрэлцээ, аймаг, нийслэлээр

	Хадлан, бэлчээрийн талбай (мян.га)			100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо			1997\1989 хувь
	1989	1993	1997	1989	1993	1997	
АР	4536.3	4541.7	4258.1	85	89	127	149.4
БӨ	4178.6	4178.7	4376.8	56	43	61	108.9
БХ	9067.0	9067.0	10514.4	31	33	41	132.3
БУ	3173.1	3178.3	3171.2	79	85	111	140.5
ГО	8924.2	9491.4	11695.5	30	28	27	90.0
ДО	10592.4	10132.7	10628.3	20	17	20	100.0
ДД	9967.3	9966.9	10425.6	21	19	17	81.0
ДУ	7392.3	7377.9	7374.2	39	38	53	135.9
ЗА	6854.5	6855.7	7028.3	56	56	74	132.1
ӨВ	5982.9	5982.8	5926.6	68	72	95	139.7
ӨМ	14597.8	14597.7	12236.5	14	12	21	150.0
СҮ	6873.3	6876.6	8165.8	35	39	36	102.9
СЭ	1959.7	1946.0	1590.8	57	57	78	136.8
ТӨ	6040.7	5828.4	5175.5	62	65	96	154.8
УВ	5684.4	5684.2	5622.8	59	54	63	106.8
ХО	5995.5	5995.1	6595.2	50	52	53	106.0
ХӨ	5629.1	5355.3	5643.7	76	81	101	132.9
ХЭ	6405.8	6290.5	6097.1	50	45	54	108.0
ДА	190.2	190.2	203.3	110	165	162	147.3
УБ	58.2	58.2	293.2	691	1155	251	36.3
ОР	53.6	53.5	51.5	222	478	576	259.5
ГС	-	459.7	539.3	-	41	46	-
ДҮН	124156.9	124108.5	127613.7	43	43	53	123.3

Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж. 1997 онд улсын хэмжээгээр 340.2 мянган тонн тэжээлийн нэгжтэй тэнцэх хэмжээний тэжээл үйлдвэрлэсэн нь 1996 оныхоос 2.6 хувь буюу 9.0 мянган тонноор буурчээ.

Үйлдвэрлэсэн тэжээлийг нэр төрлөөр нь авч үзвэл хадлан өвс, сүрэл, багсармал тэжээлийн хэмжээ 4.8-25.6 хувиар багасаж, ногоон тэжээл, бэлтгэсэн дарш 2.0-2.2 дахин, эрдэс болон гар тэжээлийн хэмжээ 6.0-15.3 хувиар нэмэгдсэн байна.

Тэжээл үйлдвэрлэлийн хэмжээ (тэжээлийн нэгжид шилжүүлснээр) 12 аймагт буурсны дотор Дорноговь, Завхан, Дундговь аймагт 30.9-39.1 хувиар багасчээ.

1997 онд улсын хэмжээгээр 667.7 мянган тонн байгалийн хадлан бэлтгэсэн нь өнгөрсөн оныхоос 33.6 мянган тонн буюу 4.8 хувь буурчээ. Завхан, Дорноговь, Дорнод 11 аймагт бэлтгэсэн өвсний хэмжээ өмнөх оныхоос буурсан байна. (Хавсралтын хуудасны дугаар 30-34)

Тэжээлийн хэмжээг нэр төрлөөр үзүүлбэл : (мян.т)

	1986- 1990 дундаж	1991- 1995 дундаж	1995	1996	1997	1997\1996 хувь
Байгалийн хадлан	1154.2	733.7	781.5	701.3	667.7	95.2
Сүрэл	114.1	47.2	100.6	21.9	16.3	74.4
Ногоон тэжээл	255.6	23.9	6.3	1.6	3.2	200.0
Олон наст өвс	21.8	4.7	0.7	0.8	0.3	37.5
Гар тэжээл (тэж.нэгж)	21.7	9.6	15.0	9.8	11.3	115.3
Багсармал тэжээл	139.8	17.5	13.8	4.8	4.4	91.7
Бэлтгэсэн дарш	277.7	66.2	19.2	10.4	23.2	223.1
Эрдэс тэжээл	61.9	18.1	26.3	18.3	19.4	106.0
Үйлдвэрлэсэн тэжээл бүгд(тэж.нэгж)	999.4	437.9	437.3	349.2	340.2	97.4

Сүүлийн жилд нийт тэжээлд хүчит, шүүст тэжээлийн эзлэх хувийн жин буурч байна.

Үйлдвэрлэсэн тэжээлийн бүтэц, тэжээлийн хангамж

	1990	1993	1994	1995	1996	1997
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
хүчит	11.5	15.3	9.5	7.4	3.3	4.2
шүүст	7.1	3.9	2.2	1.8	1.4	2.1
бүдүүн	81.4	80.8	88.3	87.4	92.5	90.0
бусад	-	-	-	3.4	2.8	3.7
Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл (тэж.нэгж,кг)	12.5	7.8	6.5	7.1	5.5	4.9

1997 оны байдлаар хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл 1996 оныхоос 0.6 кг-аар багасч, тэжээлийн нэгжээр 4.9 кг тэжээл ногдож байгаа нь нийт малыг 2.5 хоног тэжээх нөөцтэй гэсэн үг юм.

III. Малчдын тоо, тэдний соёл, ахуйн хангамж, орлого

III.1. Малчдын тоо, насны бүлэг, нэг малчин өрхөд ногдох малын тоо. 1997 оны жилийн эцсийн мал тооллогоор улсын хэмжээгээр 183.6 мянган малчин өрхөд 409.6 мянган малчид байна. Малчдын тоо өмнөх оныхоос 3.6 хувь буюу 14.2 мянгаар нэмэгдэв.

Нийт малчдын 54.7 хувь нь 16-34 насны залуучууд, 30.1 хувь нь 35-аас тэтгэвэрт гарах хүртлэх насны хүмүүс байна. Сүүлийн жилүүдэд малчдын дотор тэтгэвэрийн насны хүмүүсийн хувийн жин буурч, 35-аас тэтгэвэрийн нас хүртлэх хүмүүсийн эзлэх хувь нэмэгдсээр иржээ. Малчдын эгнээнд 16 хүрсэн залуучууд шинээр нэмэгдэн орж байгаагийн зэрэгцээ дунд үеийнхэнч 35 насны хүмүүсээр өргөжиж байна.

Өрх, малчдын тоо, бүрэлдэхүүн

	1993	1994	1995	1996	1997	1997\1996 хувь
Малчин өрх (мян)	153.6	167.3	169.3	170.1	183.6	107.9
Малчдын тоо (мян)	347.9	377.1	390.5	395.4	409.6	103.6
Үүнээс:16- 34 насны	186.8	204.8	225.2	226.5	223.9	98.9
35-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	96.1	106.3	95.4	109.2	123.4	113.0
Тэтгэврийн насны	65.0	66.0	69.9	59.7	62.3	104.4
Насны бүрэлдэхүүн (хувиар)	100.0	100.0	100.0	100.0	100.0	
Үүнээс:16- 34 насны	53.7	54.3	57.7	57.3	54.7	
35-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	27.6	28.2	24.4	27.6	30.1	
Тэтгэврийн насны	18.7	17.5	17.9	15.1	15.2	
Нэг малчин өрхөд ногдох малын тоо* (тол)	164	160	169	172	170	98.8

* Нийт малд оногдуулж бодсоноор

1996 онд нэг малчин өрхөд улсын дунджаар 172 толгой мал ногдож байсан бол 1997 онд 170 толгой болов.

Архангай, Хөвсгөл, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай аймгийн нэг малчин өрхөд 113-137 толгой мал ногдож байхад Сэлэнгэ, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Өмнөговь, Говь-Алтай аймагт 217-257 толгой мал ногдож байна. (Хавсралт хүснэгтийн 34-р хуудаснаас үзнэ үү. Цаашид хавсралт хүснэгтийн хуудасны дугаарыг заана)

III. 2. Малчдын соёл, ахуйн хангамжийн зарим үзүүлэлт. 1997 онд нийт малчин өрхийн 10.2 хувь буюу 18.7 мянган өрх цахилгаан эх үүсгэвэрээр хангагдсаны дотор 2.3 мянган өрх салхины хөдөлгүүртэй цахилгааны эх үүсгэвэртэй байна. 1996 онд нийт малчин өрхийн 9.3 хувь буюу 15.9 мянган өрх цахилгааны эх үүсгэвэртэй байсантай харьцуулбал энэ үзүүлэлт өсчээ.

Орхон, Дархан-Уул аймаг, Улаанбаатарын малчин өрхийн 58.6-66.0 хувь, Сэлэнгэ, Хэнтий аймгийн малчин өрхийн 22.4-34.0 хувь нь цахилгаан гэрэлтэй болжээ. Харин Архангай, Баян-Өлгий, Увс, Завхан, Өвөрхангай аймгийн малчин өрхийн 2.1-5.4 хувь нь цахилгааны эх үүсгэвэртэй байгаа нь аймгууд дотроос хамгийн доогуур түвшинд байна. (Хавсралт хүснэгтийн 35-36 хуудас) Салхин хөдөлгүүртэй цахилгааны эх үүсгэвэрийг Өмнөговь, Дундговь, Дорноговь аймгийн малчид бусад аймгуудынхаас харьцангуй илүүтэй ашиглаж байна.

1996 онд малчин өрхийн 9.2 хувь буюу 15.6 мянган өрх телевизортой байсан бол 1997 онд 10.4 хувь буюу 19.0 мянга нь телевизортой болжээ. Нийслэл хот, Орхон, Сэлэнгэ, Хэнтий, Говьсүмбэр, Ховд аймгийн малчин өрхийн 18.1-60.4 хувь телевизортой байгаа нь бусад аймгуудаас дээгүүр үзүүлэлттэй байна.

1997 оны байдлаар нийт малчин өрхийн 71.1 хувь нь оёдлын машинтай, 60.9 хувь радио хүлээн авагчтай, 4.0 хувь автомашинтай, 14.3 хувь нь мотоциклтэй байна.

Судалгааны үзүүлэлтийн хүрээнд нэгтгэн дүгнэж үзвэл малчин өрхийн соёл, ахуй хангамжийн олонхи үзүүлэлт өмнөх 1996 оныхоос өссөн байна. Говийн гурван аймгийн малчин өрхийн 5.8-9.6 хувь автомашинтай, 25.8-28.4 хувь нь мотоциклтэй байгаа нь бусад аймгуудынхаас нилээд дээгүүр байна. (Хавсралт хүснэгтийн 36-р хуудаснаас үзнэ үү)

Малчин өрхийн соёл, ахуйн хангамжийн зарим үзүүлэлт

	Өрхийн тоо (мян.)				1997\1996 хувь	Малчин өрхийн тоонд эзлэх хувь	
	1994	1995	1996	1997		1996	1997
Цахилгаан гэрэлтэй	19.7	19.1	15.9	18.7	117.6	9.3	10.2
Үүнээс:Салхины хөдөлгүүртэй	1.6	1.9	2.3	121.1	1.1	1.3
Телевизортой	10.9	16.8	15.6	19.0	121.8	9.2	10.4
Богино долгио- ны холбоотой*	308	316	16	45	281.3	0.0	0.0
Радио хүлээн авагчтай	114.1	111.3	106.4	111.9	105.2	62.5	60.9
Автомашинтай	4.9	6.0	7.3	121.7	3.5	4.0
Мотоциклтэй	26.7	25.0	26.2	104.8	14.7	14.3
Оёдлын машинтай	125.6	120.9	130.6	108.0	71.1	71.1

* Өрхийн тоогоор

Нийт малчин өрхийн дотор 51-500 малтай өрхүүд дийлэнх буюу 71.0 хувь, малынх нь 81.6 хувийг эзлэж байна.

30 хүртэл малтай малчин өрхийн нэлээд хэсэг нь төв суурингийн ойролцоо амьдардаг учраас цахилгаан, телевизорын хангамж харьцангуй дээгүүр байхад 31-500 малтай малчин өрхүүд автомашин, мотоциклийн хангамжаар тэднээс илүү байна.

Малчин өрхийн дотроос цахилгаан, телевизор, автомашин, мотоциклийн хангамжийн үзүүлэлтээр 1000-2000 малтай өрх хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Малчдын өрх, малын бүлэглэлт, соёл ахуйн үзүүлэлт. 1997 оны байдлаар

	Өрхийн тоо	Малын тоо (мянга)	Дүнд эзлэх хувь		Өрхийн хэдэн хувь нь			
			өрхийн тоо	малын тоо	цахилгаан гэрэлтэй	телевизортой	автомашинтай	мотоциклтэй
10хүртэл малтай	9420	58.7	5.1	0.2	17.0	14.1	0.8	3.6
11-30-“-	18149	387.5	9.9	1.5	12.5	10.5	1.1	5.4
31-50-“-	21067	869.6	11.5	3.5	8.9	9.2	2.2	9.7
51-100-“-	44341	3376.3	24.2	13.5	6.8	7.2	2.2	9.4
101-200	53510	7689.7	29.1	30.7	7.1	7.8	3.3	13.1
201-500	32478	9387.9	17.7	37.4	12.5	13.8	7.5	26.7
501-999	4075	2593.8	2.2	10.3	42.9	41.4	28.3	64.9
1000-1499-“-	528	592.8	0.3	2.4	60.8	54.5	40.9	65.0
1500-2000-“-	54	89.7	0.0	0.4	68.5	53.7	37.0	55.6
2001-ээс дээш	14	32.2	0.0	0.1	28.6	28.6	35.7	50.0
ДҮН	183636	25078.2	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

III. 3. Малчин өрхийн орлого. 1997 оны жилийн эцсийн мал тооллоготой хамтруулан малчин өрхийн 11.2 хувь буюу 19 мянган өрхөд мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын орлогын хэмжээг тодорхойлох түүвэр судалгааг явуулав.

Судалгааны зорилго нь малчин өрхийн мал аж ахуйн бүтээгдэхүүнээс гадагш худалдан борлуулсан орлогын хэмжээг малын тоо толгойн бүлэглэлтэй холбон судлах, нэг өрхийн орлогын дундаж хэмжээг сум, аймаг, улсын түвшинд тодорхойлох явдал байв. Малчин өрхийн орлогын хэмжээг тодорхойлохдоо өрхийн аж ахуйн дотоодын хэрэглээг тооцож оруулах зорилт тавиагүй болно.

Судалгааны дүнгээс үзвэл 10 хүртэл малтай малчин өрхийн жилийн дундаж орлого 71 мянган төгрөг байхад 2000-аас дээш малтай өрхийн жилийн дундаж орлого 4.2 сая төгрөг болж байна. Малчдын дотроос бизнесийн хүрээнд хамгийн жин, нөлөөтэй хэсэг нь 51-500 малтай өрхүүд бөгөөд эдгээр өрхүүдэд нийт малын 80 гаруй хувь ногдож байна.

Түүвэр судалгаанд хамрагдсан 19.1 мянган өрхийн дүнгээр нэг малчин өрх дунджаар 4.6 ам бүлтэй, 164 толгой малтай, жилдээ 421.0 мянган төгрөг, сард 35.1 мянган төгрөгийн орлоготой байна.

Өрхийн малын тоо ихсэх тутам орлого нэмэгдэж, 501-1500 хүртэл малтай өрхийн жилийн орлого 1.2-2.1 сая төгрөг, 1500-2000 малтай өрхийнх 3.5 сая төгрөг, 2001-ээс дээш малтай өрхийнх 4.2 сая төгрөг болж байна.

Малчин өрхийн мал, орлогын бүлэглэлт, 1997 оны байдлаар

	Өрхийн тоо	Малын тоо (мян.тол)	Нийт орлого (сая.төг)	Нэг өрхөд дунджаар ногдох		
				Ам бүлийн тоо	Малын Тоо	Орлого (мян.төг)
10 хүртэл малтай	1753	11.4	124.5	3.8	7	71.0
11-30 малтай	2242	49.0	272.8	4.1	22	121.7
31-50 малтай	2544	104.7	494.0	4.3	41	194.2
51-100 малтай	3953	303.6	1197.2	4.4	77	302.8
101-200 малтай	4226	626.2	1837.1	4.7	148	434.7
201-500 малтай	2978	969.3	2132.3	5.1	326	716.0
501-999 малтай	1095	729.0	1343.7	5.7	666	1227.1
1000-1499 малтай	229	257.7	482.5	6.4	1125	2107.0
1500-2000 малтай	29	47.9	100.8	5.8	1651	3475.4
2001-ээс дээш малтай	9	21.6	37.9	5.4	2403	4215.3
ДҮН	19058	3120.4	8022.8	4.6	164	421.0

Өрхийн орлогын дүнд мал, мах борлуулсны орлого 45.8 хувь, ноос, ноолуур, хөөвөр, хялгасны орлого 29.3 хувь, арьс, ширний орлого 13.3 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүний орлого 9.0 хувийг эзлэж байна.

Мал аж ахуйгаас орсон орлогын 30.3 хувийг хонины аж ахуй, 32.2 хувийг ямааны, 22.6 хувийг үхрийн, 9.3 хувийг адууны, 3.0 хувийг тэмээний аж ахуй бүрдүүлж байна.

Малчин өрхийн орлого, орлогын бүрэлдэхүүн

	Борлуулалтын орлогын бүтэц бүрэлдэхүүн (хувиар)	
	1996	1997
Орлого, бүтээгдэхүүний төрлөөр :		
Мал, махны борлуулалтын орлого	43.6	45.8
Сүү, сүүн бүтээгдэхүүний орлого	6.2	9.0
Ноос, ноолуур, хөөвөр, хялгасны орлого	26.8	29.3
Арьс, ширний орлого	20.7	13.3
Бусад орлого	2.4	2.6
ДҮН	100.0	100.0
Орлого, мал аж ахуйн төрлөөр		

Тэмээний аж ахуйгаас	2.7	3.0
Адууны аж ахуйгаас	7.7	9.3
Үхрийн аж ахуйгаас	20.5	22.6
Хонины аж ахуйгаас	36.1	30.3
Ямааны аж ахуйгаас	30.6	32.2

Адуу, үхэр, хонь, тэмээний аж ахуйд борлуулалтын орлогын 51-70 хувийг махны үйлдвэрлэлт эзэлдэг байхад ямааны аж ахуйд 15 хувийг эзэлж байна.

Тэмээний аж ахуйн хувьд ноосноосоо махны орлого нь давамгайлж, хонины аж ахуйд мах, арьсны орлого бүх орлогод нь зонхилох байр суурьтай болсон нь тэмээ, хонины тоо толгой буурах үндсэн шалтгаан болж байна. Ямааны аж ахуйд нийт орлогын 73.0 хувийг ноолуурын орлого эзлэх болов.

Малчин өрхийн орлогод голлох суурийг эзэлдэг мал аж ахуйн төрөл, бүс нутгаар, 1997 оны байдлаар (хувиар)

Хангай, тал хээрийн бүсийн аймаг	Үхрийн аж ахуйн орлого	Хонины аж ахуйн орлого	Адууны аж ахуйн орлого	Говь, Их нуурын хотгорын бүсийн аймаг	Ямааны аж ахуйн орлого	Тэмээний аж ахуйн орлого
Архангай	33.8	29.0	17.1	Баянхонгор	50.8	4.4
Булган	32.7	28.3	16.0	Говь-Алтай	46.0	3.3
Дорнод	39.0	36.4	7.8	Дорноговь	40.5	6.3
Завхан	20.3	37.4	8.2	Дундговь	37.6	5.1
Өвөрхангай	19.6	31.2	9.7	Өмнөговь	64.4	17.4
Сүхбаатар	26.0	32.4	8.4	Ховд	38.3	3.3
Сэлэнгэ	45.7	21.6	8.5	Увс	29.4	3.9
Төв	33.0	31.8	16.8	Баян-Өлгий	28.9	2.6
Хөвсгөл	30.5	31.8	8.6			
Хэнтий	41.3	24.7	12.3			
Дархан-Уул	40.6	32.6	8.4			
Улаанбаатар	47.6	21.7	16.3			
Орхон	45.9	30.7	11.4			
Говьсүмбэр	36.1	32.2	11.4			

Судалгаагаар говийн бүсийн аймгууд болон Төв, Завхан, Булган, Сэлэнгэ зэрэг аймгуудын өрхийн дундаж орлого улсын дунджаас дээгүүр байна. Энэ нь нэгдүгээрт эдгээр аймгийн нэг өрхөд ногдох малын тоо, түүний бүрэлдэхүүнтэй, хоёрдугаарт зах зээлийн орчин нөхцөлтэй холбоотой байна.

Малчдын дотроос сарын дундаж орлого нь 5.9-10.1 мянган төгрөгнөөс хэтрэхгүй байгаа 10 хүртэл болон 11-30 малтай өрхүүд хамгийн бага орлоготой нь юм. Говийн бүсийн аймгуудад 30 хүртэл малтай өрхийн эзлэх хувийн жин харьцангуй бага байна.

Судалгаанд хамрагдсан малчин өрхүүдийн жилийн дундаж орлогын хэмжээгээр аймгуудыг байр эзлүүлбэл : 1997 оны байдлаар

	Өрхийн дундаж		30 хүртэл малтай өрхийн тоо	Нийт өрхөд эзлэх хувь
	Орлого (мян.төг)	Малын тоо		
1.Говьсүмбэр	969.2	359	2	8.3
2.Дундговь	773.0	358	26	3.6
3.Өмнөговь	711.5	286	24	4.3
4.Говь-Алтай	625.8	240	61	6.0
5.Баянхонгор	612.5	210	281	22.6
6.Дорноговь	564.4	244	48	12.8
7.Төв	509.9	205	150	16.0
8.Завхан	483.9	211	158	12.8
9.Сэлэнгэ	471.9	121	89	36.0
10.Булган	448.8	155	127	19.0
12.Орхон	423.6	68	46	43.0
13.Хэнтий	422.9	169	196	25.1
Улсын дундаж	421.0	164	-	21.0
14.Увс	416.0	166	209	18.6
15.Архангай	407.3	111	404	23.5
16.Ховд	398.3	192	154	17.2
17.Дорнод	398.0	240	33	8.8
18.Баян-Өлгий	382.7	119	135	15.9
19.Дархан- Уул	349.5	113	23	31.1
20.Сүхбаатар	345.7	128	134	21.6
21.Өвөрхангай	342.3	138	371	20.1
22.Улаанбаатар	130.9	55	973	48.7

ДҮГНЭЛТ, САНАЛ

1997 онд манай улсын мал сүргийн тоо өмнөх оныхоосоо 1992.2 мянгаар нэмэгдсэн нь жилийн эцэст мал тоолдог болсон сүүлийн 30 гаруй жилд үзэгдээгүй өсөлт юм. Гэвч малын өсөлт төрөл тус бүрдээ харилцан адилгүй байгаагийн дотор хонины өсөлт тогтворгүй, олон жилд нь буурсан, тэмээний тоо жилээс жилд цөөрсөөр байна.

Өнгөрсөн долоон жилд таван төрлийн малын харьцаанд болон дотоод бүтцэд томоохон өөрчлөлт гарлаа. Үхэр, бог малын дотор, эр сувай малын эзлэх хувийн жин мэдэгдэхүйц нэмэгдсэн нь, сүргийн бүтцийг сайжруулсан өөрчлөлт юм. Харин малын тоо толгойн өсөлтийн дийлэнх ямааны өсөлтөөр хангагдаж, одоо нийт малын гуравны нэг нь ямаа болоод байна. Цаашид ч ямааны тоо өсөх төлөвтэй байна.

Мал өссөнтэй холбогдон сүүлийн найман жилд бэлчээрийн даацын ачаалал 1.2 дахин нэмэгдсэн байна. Өндөр уулын болон хангайн бүсийн зарим сумдад бэлчээрийн хомсдол бодит зүйл боллоо.

Иймд 127.6 сая га бэлчээрт таван төрлийн малыг ямар харьцаатайгаар өсгөх, ямааны тоо толгойг ямар хэмжээнд байлгах талаар төрийн оновчтой бодлого боловсруулаж хэрэгжүүлэх шаардлагатай болж байна.

Мал өсч, сүргийн бүтэц сайжирсантай холбогдон манай улсын мах экспортлох боломж нэмэгдэв. Цаашдаа жилд ойролцоогоор 800-900 мянган мал буюу амьдын жингээр 40-50 мянган тонн мах экспортлох боломжтой бөгөөд үүний 40 хувь нь үхрийн мах, 42 хувь нь хониных, 18 хувь нь ямааны мах байж болох юм.

Бог мал хээлтүүлэгчийн дутагдалд ороод байна. Энэ нь мал өсгөх их нөөц боломжийг алдахад хүргэж байна. Иймд хээлтүүлэгч малыг цөөн малтай айл ч гэсэн шинээр тавьж өсгөх эдийн засгийн сонирхол, урамшлыг бий болгох, тухайлбал хуц, ухныг бэлчээрийн болон албан татвараас чөлөөлөх нь зүйтэй байна.

Мал тооллоготой хамтруулан явуулж байгаа цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн малыг ялган ангилж тоолж бүртгэх ажил хангалтгүй хийгдсээр ирлээ. Ийм учраас энэ тооллогыг ХААҮЯ-наас эрхлэн тохиромжтой улиралд бие даалган тусад нь зохион байгуулан явуулж болох юм.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН

ГАЗРЫН ДЭД ДАРГА.....Б.БАТМӨНХ

1998 . 03 . 13

**Мал сүргийнхээ тоогоор улсад эхний таван байрт
орох аймаг, сумд, 1997 оны тооллогоор**

Аймгийн нэр	Малын тоо (мян.тол)	Сумын нэр	Малын тоо (мян.тол)
Нийт малын тоогоор			
1.Өвөрхангай	2718.2	1.Дундговийн Эрдэнэдалай	320.6
2.Завхан	2556.5	2.Өвөрхангайн Богд	256.4
3.Баянхонгор	2428.0	3.Өвөрхангайн Баянгол	237.5
4.Хөвсгөл	2152.3	4.Баян-Өлгийн Дэлүүн	221.8
5.Говь-Алтай	2112.5	5.Баянхонгорын Бууцагаан	218.3
Тэмээгээр			
1.Өмнөговь	95.0	1.Өмнөговийн Мандал-Овоо	13.5
2.Баянхонгор	38.8	2.Өмнөговийн Ханбогд	13.0
3.Говь-Алтай	36.9	3.Баянхонгорын Баянлиг	10.5
4.Дундговь	29.7	4.Өмнөговийн Гурвантэс	9.1
5.Дорноговь	29.2	5.Дундговийн Өлзийт	8.4
Адуугаар			
1.Төв	280.3	1.Дундговийн Эрдэнэдалай	33.5
2.Өвөрхангай	258.7	2.Булганы Сайхан	25.7
3.Архангай	252.6	3.Хөвсгөлийн Цэцэрлэг	24.5
4.Хөвсгөл	227.8	4.Өвөрхангайн Баян-Өндөр	24.5
5.Завхан	204.8	5.Хөвсгөлийн Цагаан - Уул	24.2
Үхрээр			
1.Хөвсгөл	442.2	1.Өвөрхангайн Уянга	45.7
2.Архангай	403.2	2.Архангайн Тариат	37.7
3.Завхан	283.8	3.Завханы Их-Уул	33.5
4.Өвөрхангай	271.8	4.Хөвсгөлийн Цагаан-Уул	33.5
5.Төв	248.9	5.Хөвсгөлийн Цэцэрлэг	32.1
Хониор			
1.Завхан	1347.6	1.Дундговийн Эрдэнэдалай	154.6
2.Өвөрхангай	1306.8	2.Өвөрхангайн Баянгол	138.2
3.Төв	1094.8	3.Баян-Өлгийн Дэлүүн	104.0
4.Увс	956.7	4.Өвөрхангайн Сант	102.8
5.Дундговь	901.4	5.Хөвсгөлийн Цагаан-Уул	101.8
Ямаагаар			
1.Баянхонгор	1191.4	1.Өвөрхангайн Богд	160.2
2.Говь-Алтай	992.5	2.Баянхонгорийн Бууцагаан	126.8
3.Өмнөговь	869.7	3.Өмнөговийн Гурвантэс	123.5
4.Өвөрхангай	961.7	4.Баянхонгорийн Баянцагаан	116.1
5.Ховд	805.0	5.Баянхонгорийн Баацагаан	106.9

**Олон малтай малчин өрхийн тоо, аймаг нийслэлээр.
1997 оны байдлаар**

	Нийт малаар			Тэмээгээр	Адуугаар	Үхрээр	Хониор	Ямаагаар
	1000-2000 малтай	2001-3000 малтай	3000-с дээш малтай	200-гаас дээш тэмээтэй	300-гаас дээш адуутай	250-с дээш үхэртэй	1000-с дээш хоньтой	800-аас дээш ямаатай
Архангай	27	2	-	-	1	-	5	-
Баян-Өлгий	6	-	-	-	-	-	-	-
Баянхонгор	65	1	-	1	-	-	3	7
Булган	45	3	-	-	1	2	7	-
Говь-Алтай	46	3	-	1	-	-	6	2
Дорноговь	12	-	-	-	-	1	-	-
Дорнод	15	-	-	-	1	-	6	-
Дундговь	71	-	-	-	1	-	1	-
Завхан	56	3	-	-	2	-	8	-
Өвөрхангай	20	1	-	-	1	-	5	1
Өмнөговь	29	-	-	6	-	-	-	7
Сүхбаатар	29	-	-	-	1	1	5	-
Сэлэнгэ	9	-	-	-	-	-	4	-
Төв	44	-	1	-	5	2	8	-
Увс	28	-	-	-	-	-	2	1
Ховд	31	-	-	-	-	-	1	1
Хөвсгөл	14	-	-	-	-	-	1	2
Хэнтий	33	-	-	-	-	2	1	-
Дархан-Уул	1	-	-	-	-	-	-	-
Улаанбаатар	1	-	-	-	-	-	-	-
Орхон	-	-	-	-	-	-	-	-
Говьсүмбэр	3	-	-	-	-	-	-	-
ДҮН	585	13	1	8	13	8	63	21